



VII/2022

Тархаасан: 2022 оны 8 дугаар сарын 15




Нас гүйцсэн эр хонины үнэ Баян-Өлгий аймагт 265.0 мянган төгрөгт хүрлээ

Малын зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2022 оны 7 дугаар сард атны үнэ 1.5 сая төгрөг болж, өмнөх сараас 6.9 мянган төгрөгөөр өссөн байна.


Харин соёолон үрээнийх 1.1 сая төгрөг болж, өмнөх сараас 5.7 мянган төгрөгөөр, хязаалан гуных 1.4 сая төгрөг болж, өмнөх сараас 3.3 мянган төгрөгөөр, эр хонины үнэ 229.3 мянган төгрөг болж, өмнөх сараас 5.0 мянган төгрөгөөр, эр ямааны үнэ 157.5 мянган төгрөг болж, өмнөх сараас 4.0 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

ЗУРАГ 1. НАС ГҮЙЦСЭН МАЛЫН ДУНДАЖ ҮНЭ (сум), мянган төгрөгөөр




Эр хонины үнэ 2022 оны 7 дугаар сард Баян-Өлгий аймагт 265.0 мянган төгрөг болж, өмнөх сараас 12.3 мянган төгрөгөөр буурсан бол Хэнтий аймагт 179.4 мянган төгрөг болж, өмнөх сараас 2.4 мянган төгрөгөөр өссөн байна.

ЗУРАГ 2. НАС ГҮЙЦСЭН ЭР ХОНИНЫ ДУНДАЖ ҮНЭ, 2022 оны 7 дугаар сард, мянган төгрөг




Үхрийн 2 метрээс дээш урттай шир 2022 оны 7 дугаар сард 5.2 мянган төгрөг болж, өмнөх сараас 0.4 мянган төгрөгөөр, ямааны цагаан ноолуурын 1 кг-ын үнэ 92.8 мянган төгрөг болж, өмнөх сараас 3.2 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

ЗУРАГ 3. МАЛ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 7 дугаар сард, төгрөг



Цагаан ноолуурын 1 кг-ын үнэ 2022 оны 7 дугаар сард Өвөрхангай аймагт 110.0 мянган төгрөг байгаа бол Булган болон Орхон аймагт 80.0 мянган төгрөг байна.

ЗУРАГ 4. ЦАГААН НОолуурын 1 кг-ын дундаж үнэ, 2022 оны 7 дугаар сард



Тооцох аргачлал:

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн судалгааг сар бүр, сум, дүүрэг, аймаг, нийслэлийн худалдааны цэгүүдээс авч нэгтгэн сарын дундаж үнийг арифметик дунджаар тооцно.



Эх үүсвэр:

ҮСХ, ХАА-н бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээ

Мэдээлэл авах холбоос

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 9 дүгээр сарын 13

Эдийн засгийн статистикийн газрын дарга
А.Дэмбэрэл
Утас : (976-51)-329271

Эдийн засгийн статистикийн газрын
Үнийн статистикийн хэлтсийн статистикч
Г.Ануужин
Утас : (976-51)-261559



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212